



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2004 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

“Улаанбаатарбуян” хязгаарлагдмал
хариуцлагатай компанийн гэрээ,
дүрэм батлах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 48 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2004 оны 180 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг, Нийслэлийн өмчийн оролцоотой “Улаанбаатарбуян” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг өөрчлөн байгуулж, байгаатай холбогдуулан хамтарсан компаний гэрээг нэгдүгээр хавсралтаар, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр, Хамтарсан компаний гэрээ, дүрмийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2004 оны
5-р дугаар сарын 17-ны өдрийн
217-дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
/НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР/
НЬЮ-МАЙНД ХХК-ИЙН ХАМТАРСАН "УЛААНБААТАРБУЯН"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГЭРЭЭ**

Ерөнхий зүйл

Монгол улсын холбогдох хуулийн дагуу хуулийн этгээд болох Нийслэлийн Засаг даргын тамгын газар /Нийслэлийн Өмчийн харилцааны газар/ /цаашид "А" тал гэх/, нөгөө талаас Нью Майнд ХХК /цаашид "Б" тал гэх/, цаашид хамтад нь "Талууд" гэх, Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон хязгаарлагдмал хариуцлагатай хамтарсан компани байгуулах /цаашид компани гэх/ зорилгоор доорхи зүйлийг харилцан тохиролцов.

**Нэгдүгээр зүйл
Компанийн зорилго, үйл ажиллагаа**

1. Компани нь доорхи үйл ажиллагааг явуулах зорилготой. Үүнд:

- А/ Оршуулгын ажлыг гүйцэтгэх одоогийн арга барил, нөхцөл байдлыг өөрчлөх
- Б/ Оршуулгын ажилтай холбогдох иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад шууд ба шууд бусаар учрах хөрөнгө, мөнгө, цаг хугацаа бусад хүчин зүйлийн зардал, хохирлыг багасгах
- В/ Иргэдэд ёс суртхууны болон зан үйлийн тохиромжит нөхцөл байдлыг бий болгох зорилготой.

**Хоёрдугаар зүйл
Оролцогч талууд**

1. Энэхүү гэрээний оролцогч талууд нь:

"А" талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
/Нийслэлийн өмчийн харилцааны газар/

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6-р хороо
Утас: 328922, 326676

Хаяг: ЧД. Жигжиджавын гудамж – 2
Утас: 320248, 315706
Факс: 976-11-320248

"Б" талаас Нью Майнд ХХК

Хаяг: СБ дүүрэг 5-р хороо Үндсэн хуулийн гудамж Ш/х-325 УБ-210628
Утас: 326585
Факс: 00976-313001

Гуравдугаар зүйл
Талуудын эрх, үүрэг

Оролцогч талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1."А" тал дараахь үүрэгтэй байна:

1.1. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үед дүрмийн санг Компанийн тухай хуулийн дагуу бүрдүүлэх.

1.2. Шинээр байгуулагдах компанид шарил чандарлах болон оршуулах үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан шаардагдах зөвшөөрөл, дүгнэлтүүдийг гаргуулж өгөх.

1.3. Компани байгуулахтай холбогдуулан "Иргэдэд үйлчлэх Буян компани" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хамтарсан компани байгуулагдах өдрөөр тасалбар болгон зогсоож, шинээр өөрчлөн байгуулсан компанид шилжүүлэх.

1.4. Компани болон "Б" талыг шаардлагатай холбогдох хууль тогтоомжууд болон бусад мэдээллээр хангах.

2."Б" тал дараахь үүрэгтэй байна:

2.1. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үед дүрмийн санг Компанийн тухай хуулийн дагуу бүрдүүлэх.

2.2. Энэхүү гэрээний 1.3-т заасан Иргэдэд үйлчлэх Буян компанийн ажиллагсдын шинээр өөрчлөн байгуулсан компанид шилжүүлэн авч, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах.

2.3. Гэрээнд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон компанийн удирдлагад оруулах этгээдийн талар санал оруулах.

2.4. Компанид ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, сургахад дэмжлэг үзүүлэх.

2.5. Компанийг шаардлагатай түүхий эд материал, машин тоног төхөөрөмж, бусад зүйлээр хангахад дэмжлэг үзүүлэх.

3.3. "Талууд" дараахь эрх, үүрэгтэй байна:

3.1. Оролцогч талуудын байгуулсан Гэрээ, түүний хавсралт болох дүрмийн үндсэн дээр гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор холбогдох байгууллагад компанийг бүртгүүлэх, данс нээлгэх, тамга тэмдэг хийлгэх болон бусад бэлтгэл ажлыг хангах.

3.2. Шарил чандарлах болон оршуулах үйл ажиллагаа үзүүлэх "Улаанбаатарбуян" ХХК-ийг хамтран хөрөнгө оруулж, үүсгэн байгуулах.

3.3. Компанийг шаардлагатай түүхий эд, машин тоног төхөөрөмж, бусад зүйлээр хангахад дэмжлэг үзүүлэх.

3.4. Компанийн удирдлагыг бүрдүүлэхэд оролцох.

3.5. Компанийн үйл ажиллагаатай холбогдсон аливаа асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд оруулах.

3.6. Компанийн өөрт ногдох ашгийг авах.

3.7. Өөрт ногдох ашгаараа компанийн дүрмийн санд хөрөнгө дахин оруулах.

Доровдүгээр зүйл
Компанийн нэр, байршил, эрх, хэмжээ

1. Компанийн нэр:
 - монголоор "Улаанбаатарбуян" ХХКомпани.
 - латинаар "Ulaanbaatarbuyan" Co.Ltdгэж тус тус нэрлэгдэнэ.

2. Компаний албан ёсны хаяг:
 - Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
 - Утас: 329739, 328036

2. Компани нь Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр Монгол улсын хуулийн дагуу хуулийн этгээдийн эрхтэй болох бөгөөд уг өдрөөс эхлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх эдэлнэ. Компанийн хуулийн этгээд болсон өдрийг уг компани байгуулагдсан өдөр гэж үзнэ.

3. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх, хөндлөнгийн шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцох эрхтэй.

4. Компани нь энэхүү гэрээнд оролцогч талуудын хүлээсэн үүрэг хариуцлагыг хүлээхгүй ба талууд нь компанийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хүлээхгүй.

5. Компани нь хүлээсэн үүргийнхээ хувьд эд материалын хариуцлагыг зөвхөн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээнд хүлээнэ.

Тавдугаар зүйл
Дүрмийн сан

1. Компанийн дүрмийн сан нь оролцогч талуудын оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэх бөгөөд нийт хэмжээ нь 1613,6 сая төгрөг байна.

- компанийн өөрийн хөрөнгөнд "А" талын оруулах хувь нь нийт хөрөнгийн 34% буюу 548,6 сая төгрөг
- компанийн өөрийн хөрөнгөнд "Б" талын оруулах хувь нь нийт хөрөнгийн 66% буюу 1065,0 сая төгрөг байна.

2. Оролцогч талууд нь компанийн өөрийн хөрөнгөнд оруулах өөрийн хувь хөрөнгийг энэхүү гэрээний дагуу оруулна. Үүнд:

- "А" тал компанийн өөрийн хөрөнгийн 34% буюу 548,6 сая төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг гаргана. Үүнд: 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт /мөнгөн хэлбэрээр/, 298.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий "Иргэдэд үйлчлэх Буян компани" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгийг шилжүүлнэ.

- "Б" тал компанийн өөрийн хөрөнгийн 66 % буюу 1065,0 сая төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг гаргана. Үүнд:

65

-Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт буй Баруунтурууны амны 828.9 сая төгрөгийн өртөг бүхий 95 хувийн гүйцэтгэлтэй крематор сүмийн цогцолбор барилга байгууламж;

-27.1 сая төгрөгийн өртөг бүхий 35 кВт цахилгааны дэд станц;

-7.8 сая төгрөгийн өртөг бүхий гүний худаг, барилгын хамт;

-81.0 сая төгрөгийн өртөг бүхий 300 м урт 50 машины зогсоол бүхий хатуу хучилттай зам талбай;

-120.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж /урьдчилгаа төлөгдсөн/

2. Дүрмийн сангийн хэмжээг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр өөрчилж болох ба гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх тухайгаа 14 хоногийн дотор Улсын бүртгэлийн албанд мэдэгдэж зохих шийдвэрийг гаргуулсны үндсэн дээр Гэрчилгээнд өөрчлөлт оруулна.

3. Компани байгуулагдах үед талуудаас дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг нотолсон гэрчилгээг уг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл талуудад олгоно.

Зургаадугаар зүйл

Удирдлага

1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирлаар толгойлуулсан захиргаа гүйцэтгэнэ. Гүйцэтгэх захирал ба түүний орлогчийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно.

2. Гүйцэтгэх захирал ба түүний орлогч нь компанийн үйл ажиллагааг компанийн гэрээ, дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр олгосон эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 хүний бүрэлдхүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлд Нью Майнд ХХК-аас 3, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2 хүний төлөөлөлтэй байна.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийх ба төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, захиргаа, Гүйцэтгэх захирлын санаачлагаар ээлжит бус хурлыг хэзээ ч зарлан хуралдуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэх асуудлын хүрээг компанийн дүрмээр тодорхойлно.

4. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг энэхүү Гэрээ, компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр олгосон эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

Долоодугаар зүйл

Ажиллах хүч

1. Компани нь ажиллагсадтай хөдөлмөрийн болон хамтын гэрээ байгуулах, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх, цалин, шагнал урамшил, тэтгэвэр тэтгэмж олгох, хөдөлмөр хамгаалал болон хөдөлмөрийн бусад харилцааг Монгол улсын Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2. Ажиллагсдын нийгмийн даатгал болон бүх төрлийн төлбөр, хураамжийн асуудлыг компани нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3. Компани нь ажлынхаа дотоод журмыг холбогдох хууль тогтоомжийг иш үндэс болгон боловсруулж, компанийн төлөөлөн удирдах зөвлөлд оруулж батлуулна.

Наймдугаар зүйл

Компанийн эдийн засгийн үйл ажиллагаа, татвар, санхүүжилт ба хяналт

1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-нээс эхлэн /эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс/ 12 дугаар сарын 31-нд /сүүлийн жилийн хувьд энэхүү гэрээ хүчингүй болох буюу гэрээний заалт ёсоор татан буугдсан өдөр/ дуусна.

2. Компани нь холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар, газар эдэлбэр, түрээсийн төлбөрийг төлнө.

3. Компанийн санхүүгийн болон статистикийн бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлнө.

4. Оролцогч аль нэг тал нь хүсэлт гаргавал компани санхүүгийн мэдээллийг гаргаж өгч байна.

5. Компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй, талуудын тэнцүү тооны төлөөлөгчдөөс бүрдсэн Хянан шалгагчдын зөвлөлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулна. Хянан шалгагчдын зөвлөл нь 2 хүний бүрэлдхүүнтэй байх бөгөөд компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг жилд нэгээс доошгүй удаа шалгаж, дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж байна.

6. Компанид оролцогч талууд компанийн дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр ашиг олсон тухайн тайлант жилд ашгийг 1 удаа хуваарилан авна. Хэрэв компани алдагдалтай ажилласан бол түүнийг нөхөж дуустал ашгийн хуваарилалт хийхгүй.

7. Компанийн аж ахуйн үйл ажиллагааг явуулахтай холбогдсон материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад бүтээгдхүүнийг тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авч байна.

Есдүгээр зүйл

Даатгал

1. Компани нь бүх төрлийн даатгалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалын байгууллагад даатгуулж болно.

Аравдугаар зүйл

Татан буулгах

1. Компанийг дараах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр татан буулгана. Үүнд:

- Дор дурдсан аль нэг нөхцөл байдал бий болж байнга үргэлжлэх болсон гэдгийг үндэслэн нэг талын санаачлагаар талууд удирдах зөвлөлийн гишүүдээрээ дамжуулан компанийг татан буулгах тухай шийдвэрийг санал нэгтэй баталсан үед.
- үйл ажиллагааны анх тохирсон хугацаа буюу сунгасан хугацаа нь дууссан үед

а/ компани алдагдалтай ажиллаж байгаагийн улмаас цаашид үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон бол,

б/ аль нэг тал нь энэхүү гэрээний 1 дүгээр зүйлд заасан журмын дагуу компанийн дүрмийн санд өөрийн хувь хөрөнгөө нийлүүлж чадахгүй байдалд 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар орсон байвал,

в/ аль нэг тал энэхүү Гэрээ болон дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрсний улмаас компани нь үйл ажиллагаагаа цаашид явуулах боломжгүй болж, энэ Гэрээний зорилгод харшилж байгаа бол,

г/ аль нэг тал нь бодит байдал дээр Төлөөлөн удирдах зөвлөлд болон компанийн үйл ажиллагааг удирдах ажилд оролцож чадахгүйд хүрсэн байвал,

д/ харилцан тохиролцсоны үндсэн дээр компанийг татан буулгахад хүрвэл

е/ Компанийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-г зааснаар улсын бүртгэлээс хассан бол,

2. Компани нь дор дурдсан үндэслэлээр татан буугдана. Үүнд:

1/ компани дампуурсан ,

2/ компанид нэг ч гишүүн үлдээгүй,

3/ хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн,

4/ хуулинд заасан бусад үндэслэл

3. Компанийг татан буулгах тохиолдолд ор толбөрийг төлсний дараа хөрөнгий нь хувь оруулсан хэмжээгээр хувааж авах эсвэл аль нэг тал нь компанийн бүх хөрөнгө, түүний хэсгийг худалдан авах, хөрөнгийг бусдад борлуулах арга хэмжээ авна.

4. Компанийг татан буулгах тохиолдолд Татан буулгах комиссыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.

5. Татан буулгах комиссын эрх үүрэг, ажиллах журмыг компанийн дүрмээр тодорхойлно.

Арваннэгдүгээр зүйл

Хариуцлага

1. Энэхүү гэрээнд оролцогч аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг нөгөө талдаа төлөх үүрэгтэй. Гэхдээ шууд бус хохирол буюу олох байсан ашгийг нөхөн төлөхгүй.

2. Компанийн өөрийн хөрөнгөд оруулах хөрөнгийн зарим хэсгийг бүрдүүлэх боломжгүй болсноо аль нэг тал нь албан ёсоор мэдэгдвэл оруулаагүй хөрөнгийн хэмжээгээр компанийн эзэмшлийн хувиас хасна.

Арванхоёрдугаар зүйл

Давагдашгүй хүчин зүйл

Энэхүү гэрээний дагуу аль нэг тал нь хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлэхэд нь саад учруулах ямар нэгэн нөхцөл бүрэлдэх, тухайлбал гал усны аюул, дайн дажин болох, хориглолт бүслэлт хийх зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах бусад хүчин зүйл бий болбол гэрээгээр авсан үүргийг биелүүлэх хугацаа эдгээр хүчин зүйл үргэлжлэх хугацаагаар хойшилно.

Хэрэв энэ хүчин зүйл нь 3 сараас дээш хугацаагаар үргэлжилбэл аль ч тал гэрээгээр хүлээн авсан үүргээсээ татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд нөгөө талаасаа хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхгүй болно.

Дээрх хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал нь учирсан хүчин зүйлийн эхлэлт төгсөлтийг нөгөө талдаа тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

Арвангуравдугаар зүйл
Маргаан таслах

1. Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэх ба тохиролцоонд хүрэхгүй бол шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

Арван дөрөвдүгээр зүйл
Компанийн ажиллах хугацаа

Компани түүнийг байгуулсан өдрөөс хойш 3 жил үйл ажиллагааг явуулна. Энэхүү гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа нь түүнийг баталсан өдрөөс эхэлж, гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгаснаар дуусна.

Хэрэв аль нэг тал гэрээний хугацааг сунгахыг хүсвэл энэ тухай нөгөө талдаа энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа дуусахаас 6 сарын өмнө мэдэгдэнэ.

Гэрээний хугацаа сунгах талаар компанийн Зөвлөл шийдвэр гаргасан тохиолдолд Талууд татварын албанд мэдэгдэнэ.

Арвантавдугаар зүйл
Бусад зүйл

1. Энэхүү гэрээний оролцогч талууд нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

2. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд урьд өмнө нь явагдаж байсан хэлэлцээ, албан бичиг, санамж, бусад мэдээлэл хүчингүйд тооцогдоно.

Энэхүү гэрээг 2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"А" талыг төлөөлж:
Нийслэлийн Засаг дарга
бөгөөд Улаанбаатар хотын
захирагч
М.ЭНХБОЛД

"Б" талыг төлөөлж:
Нью Майнд ХХК-ийн
ерөнхий захирал
Г. ИДЭРМАА

69

Нийслэлийн Засаг даргын 2004 оны
5 дугаар сарын 13-ны өдрийн
217..... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
/НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР/
НЬЮ – МАЙНД ХХК-ИЙН ХАМТАРСАН “УЛААНБААТАРБУЯН”
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг талаас Нийслэлийн Засаг даргын тамгын газар /Нийслэлийн Өмчийн харилцааны газар/ /цаашид “А” тал гэгдэх/ нөгөө талаас “Нью Майнд” хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид “Б” тал гэгдэх/ цаашид хамтад нь “Талууд” гэгдэх, Монгол улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон хязгаарлагдмал хариуцлагатай хамтарсан компани /цаашид компани гэх/ байгуулахаар энэхүү дүрмийг үйлдэв.

Энэхүү дүрэм нь хамтарсан “Улаанбаатар буян” ХХКомпани байгуулах тухай талуудын байгуулсан 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн гэрээний салшгүй хэсэг болно.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ
Компанийн нэр, байршил

1. Компани нь:

- монголоор “Улаанбаатарбуян” ХХКомпани
- латинаар “Ulaanbaatarbuyan” Co.Ltd гэж тус тус нэрлэгдэх бөгөөд Улаанбаатар хотноо байрлана.

2. Компанийн албан ёсны хаяг нь:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо гэсэн хаягаар оршино.
Утас: 329739, 328036

ХОЁРДУГААР ЗҮЙЛ
Талууд

1. Энэхүү дүрмийн талууд нь:

“А” талаас Монгол улсын хуулийн этгээд болох Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Нийслэлийн Өмчийн харилцааны газар/

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Хаяг: ЧД. Жигжиджавын гудамж – 2
Утас: 328922, 326676 Утас: 320248, 315706
Факс: 976-11-320248

“Б” талаас Монгол улсын хуулийн этгээд болох “Нью Майнд” хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хаяг: СБДүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж ш/х-325 УБ 210628
Утас: 326585
Факс: 00976-313001

ГУРАВДУГААР ЗҮЙЛ
Компанийн эрх, хэмжээ

1. Компани нь Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр Монгол улсын хуулийн дагуу хуулийн этгээдийн эрхтэй болох ба Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ -ийн эрх хэмжээтэй байна.

2. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх, хондлогчийн шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцох эрхтэй.

3. Компани нь талуудын хүлээсэн үүргийг хариуцахгүй ба талууд нь компанийн хүлээсэн үүргийг хариуцахгүй.

4. Компани нь хүлээсэн үүргийнхээ хувьд эд материалын хариуцлагыг зөвхөн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээнд хүлээнэ.

5. Компани нь бүхий л үйл ажиллагаандаа хамтарсан компани гэдэг нэрийг хэрэглэнэ.

6. Компани нь өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байх бөгөөд тэдгээрийн загварыг батална.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ
Компанийн зорилго, үйл ажиллагаа

1. Компани нь доорхи үйл ажиллагааг явуулах зорилготой. Үүнд:

- А/ Оршуулгын ажлыг гүйцэтгэх одоогийн арга барил, нөхцөл байдлыг өөрчлөх
- Б/ Оршуулгын ажилтай холбогдох иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад шууд ба шууд бусаар учрах хөрөнгө, мөнгө, цаг хугацаа бусад хүчин зүйлийн зардал, хохирлыг багасгах
- В/ Иргэдэд ёс суртхууны болон зан үйлийн тохиромжит нөхцөл байдлыг бий болгох зорилготой.

ТАВДУГААР ЗҮЙЛ
Дүрмийн сан

1. Компанийн дүрмийн сан нь оролцогч талуудын оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэх бөгөөд нийт хэмжээ нь 1613,6 сая төгрөг байна.

- Компанийн өөрийн хөрөнгөнд "А" талын оруулах хувь нь нийт хөрөнгийн 34% буюу 548,6 сая төгрөг
- Компанийн өөрийн хөрөнгөнд "Б" талын оруулах хувь нь нийт хөрөнгийн 66% буюу 1065,0 сая төгрөг байна.

2. Оролцогч талууд нь компанийн өөрийн хөрөнгөнд оруулах өөрийн хувь хөрөнгийг энэхүү гэрээний дагуу оруулна. Үүнд:

- "А" тал компанийн өөрийн хөрөнгийн 34% буюу 548,6 сая төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг гаргана. Үүнд: 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт /мөнгөн хэлбэрээр/, 298,6 сая төгрөгийн балансын үнэ бүхий "Иргэдэд үйлчлэх Буян компани" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгийг шилжүүлнэ.

- "Б" тал компанийн өөрийн хөрөнгийн 66 % буюу 1065,0 сая төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг гаргана. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт буй Баруунтурууны амны 828.9 сая төгрөгийн өртөг бүхий 95 хувийн гүйцэтгэлтэй крематор сүмийн цогцолбор барилга байгууламж;

- 27.1 сая төгрөгийн өртөг бүхий 35 кВт цахилгааны дэд станц;

- 7.8 сая төгрөгийн өртөг бүхий гүний худаг, барилгын хамт;

- 81.0 сая төгрөгийн өртөг бүхий 300 м урт 50 машины зогсоол бүхий хатуу хучилттай зам талбай;

- 120.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж /урьдчилгаа төлөгдсөн/

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Төлөөлөн удирдах зөвлөл

1. Компанийн удирдах дээд байгууллага нь оролцогч талуудын томилсон 5 хүний бүрэлдхүүнтэй байх ба 3 хүнийг Нью Майнд ХХК-аас, 2 хүнийг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газраас томилсон төлөөлөн удирдах зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ байна. Зөвлөлийн гишүүд нь хурлыг зарлах, зохион байгуулах, удирдан явуулах эрх бүхий Зөвлөлийн даргыг сонгоно. Зөвлөлийн даргыг Зөвлөлийн хурлаас сонгох ба Зөвлөлийн олонх гишүүд шаардлагатай гэж үзвэл хугацаанаас нь өмнө огцруулж болно.

2. Зөвлөлийн ээлжит хурлыг сард нэгээс доошгүй удаа хийх ба Зөвлөлийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирлын санаачилгаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

3. Зөвлөл нь компанийн удирдах дээд байгууллагын хувьд компанийн үйл ажиллагаа, удирдлага, хяналт шалгалтын бүх асуудлыг зохицуулан чиглүүлнэ. Зөвлөл нь асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4. Талуудын аль нь ч өөрийн талаас томилсон Зөвлөлийн гишүүнийг ямар ч тайлбаргүйгээр солих эрхтэй. Энэ тухайгаа нөгөө талд болон компанийн захиргаанд албан бичгээр мэдэгдэнэ.

5. Зөвлөлийн дарга энэхүү сонгуульт ажлаасаа өөрчлөгдөх буюу ямар нэг шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрвэл даргын үүргийг орлогч буюу Зөвлөлийн өөр нэг гишүүн гүйцэтгэж болно.

6. Хурлыг дарга удирдана. Зөвлөлийн хурал хийх хугацаа, хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн гишүүдэд хурал эхлэхээс өмнө 3 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдсэн байна.

7. Зөвлөлийн анхны хурлыг Зөвлөлийн дарга компани байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор зарлан хуралдуулж болно.

8. Зөвлөл нь гишүүдийн гуравны хоёр нь /төрийн төлөөлөл оролцсон байх / оролцсон тохиолдолд хуралдаж шийдвэр гаргана.

Зөвлөлийн аль нэг гишүүн хуралд оролцох боломжгүй бол өөрийн оронд итгэмжлэгдсэн хүнээ оролцуулж болно. Зөвлөлийн тухайн гишүүн өөрийн итгэмжилсэн хүнийхээ талаар хуралдаан эхлэхээс өмнө Зөвлөлийн хуралдааны даргад өөрийн гарын үсэг бүхий бичгээр мэдэгдэнэ. Зөвлөлийн гишүүний итгэмжлэгдсэн этгээд түүнийг төлөөлж нэг удаа санал өгөх эрхтэй бөгөөд хэрэв итгэмжлэгдсэн этгээд өөрөө Зөвлөлийн гишүүн байвал хоёр дахь удаагаа өөрийн санааа өгөх эрхтэй.

9. Зөвлөлийн гишүүн бүр нэг удаа санал өгөх эрхтэй. Саналын тоо тэнцсэн үед дарга /түүнийг эзгүйд орлож буй этгээд/ -ын санал шийдвэрлэх үүрэгтэй.

10. Зөвлөл дараахь асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:

- компанийн эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох
- компанийн удирдлагын аппаратын зохион байгуулалт болон үйлдвэрлэлийн эрхлэлт, зохион байгуулалт, цалингийн сан, урамшуулал
- компанийн жилийн болон хэтийн төлөвлөгөө, төсөв, жилийн тайлан тэнцлийг хэлэлцэн батлах
- компанийн дүрмийн сангийн хэмжээ, түүнд талуудын эзлэх хувь хэмжээг өөрчлөх
- компанийн ашгийг хуваарилах, сангуудыг байгуулах, нийгмийн хангамж, тэтгэвэр тэтгэмжийг батлах
- компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаархи Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох
- хянан шалгагчдын зөвлөлийн гишүүнийг сонгох, тэдгээрт олгох цалин хөлс, урамшууллыг тогтоох
- компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
- компанид гишүүн элсүүлэх, компаниас гарч буй гишүүдтэй тооцоо хийх
- компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, гуравдагч этгээдэд эрхээ шилжүүлэх

11. Зөвлөлийн хурлын протоколыг Зөвлөлийн даргын сонгосон нарийн бичгийн дарга /тэрээр Зөвлөлийн гишүүн байх албагүй/ хөтөлнө.

Нарийн бичгийн дарга нь хуралдаан бүрийн протоколыг хуралдаан болсноос хойш 14 хоногийн дотор Зөвлөлийн гишүүдэд тараана. Аль нэг гишүүн протоколд нэмэлт өөрчлөлт оруулахыг хүсвэл уг протоколыг хүлээж авснаас хойш 10 хоногийн дотор энэ тухайгаа дарга болон Зөвлөлийн гишүүдэд бичгээр мэдэгдэнэ. Протоколд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дээрхи саналын талаар санал нийцэхгүй байгаа бөгөөд уг асуудлыг шийдвэрлэх нь чухал гэж үзвэл Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна. Хэрэв уг асуудал тухайн

хуралдаанаар шийдэгдэхгүй бол Зөвлөлийн дараагийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

Зөвлөлийн хурлын протоколд хэлэлцсэн буюу шийдвэрлэсэн зарим асуудлыг орхигдуулсан байвал протоколыг хүлээн авснаас хойш 7-10 хоногийн дотор Зөвлөлийн дарга болон бусад гишүүдэд мэдэгдэнэ.

Зөвлөлийн хурлын протоколыг Зөвлөлийн бүх гишүүд гарын үсэг зурж баталмагц Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж, оролцогч талуудад нэг нэг хувийг хадгалуулна.

Протокол батлагдсанаар хэлэлцэх асуудал шийдвэрлэгдсэнд тооцно.

Протоколын хэрэг нь Зөвлөлийн гишүүн тэдгээрийн эрх бүхий төлөөлөгчдөөс хянан шалгах, хувиан авахад нээлттэй байна.

Зөвлөлийн гишүүдийн томилогдсон буюу оорчлогдсон тухай, түүнчлэн тухайн гишүүдийн ажил байдал, хаягийн тухай мэдээллийг протоколд дурдсан байна. Мөн хуралдааны тухай бүхий л тэмдэглэл, хэлэлцэх хэргийн төлөвлөгөө, итгэмжлэгдсэн хүмүүсийн тухай материал мөн протоколын хэрэгт орно.

12. Шаардлагатай үед Зөвлөлийн хурал хийлгүйгээр гишүүд гарын үсэг зурах замаар асуудлыг шийдвэрлэж болно. Гэхдээ энэ шийдвэр нь энэ зүйлийн 9, 10, 11 дүгээр заалтууд болон бусад шаардлагыг хангасан байна.

13. Зөвлөлийн жилийн ажлын төсвийг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.

ДОЛДУГААР ЗҮЙЛ Удирдлага

1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирлаар толгойлуулсан захиргаа гүйцэтгэнэ. Гүйцэтгэх захирал ба түүний орлогчийг жилийн хугацаагаар Зөвлөлийн хурлаас томилно.

2. Гүйцэтгэх захирал ба түүний орлогч нь компанийн үйл ажиллагааг компанийн гэрээ, энэхүү дүрэм, Зөвлөлийн хурлын шийдвэрээр олгосон эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

3. Компанийн захиргаа нь доорхи үүрэг хүлээнэ. Үүнд:

- компанийг бүртгүүлэх, данс нээлгэх, тамга тэмдэг хийлгэх болон бусад зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх
- компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай холбогдох байгууллагын зөвшөөрөл баримт материалыг бүрдүүлэх, экспорт импортын лицензийг авах, худалдаа үйлчилгээнд шаардлагатай бараа материалыг нийлүүлэх
- компанийг ажиллах боловсон хүчнээр хангах боловсон хүчний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх
- компанийн үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулах
- компанийн техник технологийг шинэчлэх, ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх
- тайлан тэнцэл болон компанийн эд хөрөнгийн талаарх мэдээ тайланг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийн хамт компанийн үйл ажиллагааны талаар гишүүдэд мэдээлэх, санхүүгийн баримт бичигтэй танилцах боломж тэдэнд олгох
- компаниас гаргасан мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

4. Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх, шүүх, хөндлөнгийн шүүхийн ажиллагаанд оролцож, санхүүгийн баримт бичигт гарын үсэг зурах, Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах эрхтэй.

5. Гүйцэтгэх захирал хувийн эрх ашгийн үүднээс компанийн нэрийг ашиглан гэрээ, хэлцэл хийхийг хориглоно. Түүнчлэн Зөвлөлийн хурлын зөвшөөрөлгүйгээр өөр аж ахуйн нэгжийн гишүүн болон удирдлагад байхыг хориглоно.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

Компанийн эдийн засгийн үйл ажиллагаа, татвар, санхүүжилт ба хяналт

1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-нээс эхлэн /эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс/ 12 дугаар сарын 31-нд /сүүлийн жилийн хувьд энэхүү гэрээ хүчингүй болох буюу гэрээний заалт ёсоор татан буугдсан өдөр/ дуусна.

2. Компани нь холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар, гаалийн хураамж, газар эдэлбэр, түрээсийн төлбөрийг төлнө.

3. Компанийн санхүүгийн болон статистикийн бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлнө.

4. Компани холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогоосоо улсын төсөвт татвар төпсний дараа нөөцийн болон бусад сангуудыг өөрийн эдийн засгийн байдлыг харгалзан Зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр байгуулж болно.

5. Компанийн санхүүгийн тайлан, тэнцлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу холбогдох татварын байгууллага шалгах эрхтэй бөгөөд холбогдох баримт материалыг шаардан гаргуулах эрхтэй.

6. Компани нь улирал болон жил бүрийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааныхаа талаархи тайланг орлого зарлагын тайлан тэнцэтгэлийн хамт талуудын холбогдох татварын байгууллагад өгч байх үүрэгтэй.

7. Хянан шалгагчид нь компанийн Зөвлөл буюу захиргаанд ямар нэгэн албан үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

8. Хянан шалгагчид нь компанийн Зөвлөлийн өмнө хариуцлага хүлээнэ. Компанийн Гүйцэтгэх захирал, түүний орлогч нь шалгалт хийхэд шаардагдах бүх баримт, материалыг хянан шалгагчдын зөвлөлийн мэдэлд саадгүй огч шалгалт хийх нөхцлийг хангана.

9. Санхүүгийн тайлан, балансыг улирал, жилээр гаргана.

10. Компанийн бүртгэл, тооцооны нэгжийг төгрөгөөр илэрхийлнэ.

11. Компанийн дүрмийн санд оролцогч талуудаас оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр ашгаа жилд 1 удаа хуваарилж авна. Хэрэв компани алдагдалтай ажилласан бол түүнийг нөхөж дуустал ашгийн хуваарилалт хийхгүй байж болно.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Компанийн үйл ажиллагааг зогсоох

1. Компанийг татан буулгах тохиолдолд комиссыг Зөвлөлөөс томилно.

2. Компанийг дараах үндэслэлээр Зөвлөлийн хурлын шийдвэрээр татан буулгана. Үүнд:

- үйл ажиллагааны анх тохирсон хугацаа буюу сунгасан хугацаа нь дууссан үед,
 - дор дурдсан аль нэг нөхцөл байдал бий болж байнга үргэлжлэх болсон гэдгийг үндэслэн нэг талын санаачлагаар талууд Зөвлөлийн гишүүдээрээ дамжуулан компанийг татан буулгах тухай шийдвэрийг санал нэгтэй баталсан үед.
- Үүнд:

А/ компани алдагдалтай ажиллаж байгаагийн улмаас цаашид үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон бол,

Б/ аль нэг тал нь энэхүү гэрээний 4 дүгээр зүйлд заасан журмын дагуу компанийн дүрмийн санд өөрийн хувь хөрөнгөө нийлүүлж чадахгүй байдалд орсон байвал,

В/ аль нэг тал энэхүү Гэрээ болон дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрсний улмаас компани нь үйл ажиллагаагаа цаашид явуулах боломжгүй болж, энэ Гэрээний зорилгод харшилж байгаа бол,

Г/ аль нэг тал нь бодит байдал дээр Зөвлөлд болон компанийн үйл ажиллагааг удирдах ажилд оролцож чадахгүйд хүрсэн байвал,

Д/ харилцан тохиролцсоны үндсэн дээр компанийг татан буулгахад хүрвэл

Е/ Компанийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т зааснаар улсын бүртгэлээс хассан бол,

3. Компани нь дор дурдсан үндэслэлээр татан буугдана. Үүнд:

1/ Компани дампуурсан ,

2/ компанид нэг ч гишүүн үлдээгүй,

3/ хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн,

4/ хуулинд заасан бусад үндэслэл

4. Компанийг татан буулгах тохиолдолд өр төлбөрийн төлсний дараа хөрөнгий нь хувь оруулсан хэмжээгээр хувааж авах эсвэл аль нэг тал нь компанийн бүх хөрөнгө, түүний хэсгийг худалдан авах, хөрөнгийг бусдад борлуулах арга хэмжээ авна.

5. Энэхүү зүйлд заасны дагуу компанийг татан буулгах тохиолдолд оролцогч аль нэг тал холбогдох байгууллагын зохих зөвшөөрлийг авсан нөхцөлд компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлж болно. Ийм зорилт тавьж байгаа оролцогч тал компанийн үндсэн хөрөнгийг оролцогч бусад талтай тохиролцсон үнээр худалдан авна.

Үнэ тогтоосны дараа талууд компанийн өмч худалдаж авахтай холбогдсон журмын шаардлагыг хангаж зохих зөвшөөрлийг авна.

6. Зөвлөл нь компанийг татан буулгах тухай шийдвэр гаргаж, компанийг татан буулгах комиссыг байгуулна.

7. Татан буулгах комисс компанийн бүх өр төлбөрийг барагдуулж зохих тооцоо хийж, нийтэд мэдээлснээс хойш 2 сарын дараа үлдсэн эд хөрөнгийг талуудад хуваарилна.

8. Компанийг татан буулгах ажиллагаа дуусмагц татан буулгах комисс даруй тайлан гаргаж Зөвлөлөөр батлуулна.

АРАВДУГААР ЗҮЙЛ

Хэрэглэгдэх хууль

Дүрмийг батлах, хүчин төгөлдөр болох, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, зогсооход холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Компани нь холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах үүрэг хүлээнэ.

Гэрээ болон дүрмийг тайлбарлах явцад гэрээний заалттай зөрчилдсөн ямар нэгэн маргаан гарвал Гэрээг баримтална.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Бусад зүйл

Гэрээнд гарын үсэг зурсантай хамт энэхүү дүрэм нь хүчин төгөлдөр болох бөгөөд урьд өмнө явагдаж байсан хэлэлцээ, албан бичиг, санамж, бусад мэдээлэл хүчингүйд тооцогдоно. Гэрээ хүчингүй болоход энэхүү дүрэм нь мөн хүчингүй болно.

Энэхүү дүрмийг 2004 оны 5 дугаар сарын 13-ний өдөр Улаанбаатар хотноо үйлдсэн болно.

